

МОНГОЛ, АНГЛИ ХЭЛЦ НЭГЖИЙН ҮҮСЭН ХЭВШИХ ЗАРИМ ОНЦЛОГООС...
(“Уур, уурлах” концептын жишээгээр)

Т. Эрдэнэ-Очир¹

Хэл нь тархины үндсэн бүтээгдэхүүний хувьд хүний сэтгэлгээг загварчлах гол хэрэглүүр болж, хиймэл оюун бүтээхэд ач холбогдолтой гэж үздэг. Мэдээллийн процессыг загварчлах, машинаар орчуулах програм боловсруулахад хэлний нэгж, загваруудыг боловсруулж хэрэглэх шаардлага өсч байна. Нэг хэлнээс нөгөө хэлнээ орчуулах цахим орчуулгын програм, олон хувилбарт толь бичиг зэргийг зохиоход үндэсний сэтгэлгээний онцлогийг тусгасан хэлний тогтвортой нэгжүүдийг зөв орчуулах нь зохих судалгаа шаардсан ихээхэн адармаатай хэрэг юм. Иймд үндэстний сэтгэлгээний онцлогийг хэлний илэрхийллээр дамжуулан судлахдаа тухайн хэлний ямар нэгжийг судлагдахуунаа болгож авах вэ гэдэг нь нэн чухал.

Хэл шинжлэлч эрдэмтдийн үзэж буйгаар, өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэг, зүйр цэцэн үг, оньсого, таавар гэх мэт хэлний тогтвортой нэгжүүд нь аль ч үндэстний эдийн болон оюуны соёлын тусгал болж, тухайн хэлээр харилцагч үндэстний сэтгэлгээний хэв шинж буюу ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдлын илэрхийлэл болж байдаг тул эдгээр хэлний тогтвортой нэгжүүдийг үндэстний сэтгэлгээний онцлогийг судлах гол судлагдахуун болгох хэрэгтэй хэмээн тэмдэглэсэн байна.

Монгол хэлний хэлц нэгжийг Б. Ринчин, Чой, Лувсанжав, М. Базаррагчаа, Ж. Баянсан, Ж. Бат- Ирээдүй, Ц. Өнөрбаян, Д. Бадамдорж, Г. Аким, Ж. Төмөрцэрэн, Д. Дашдаваа, Ц. Дашдондов, Д. Баттогтох нарын эрдэмтэн, судлаачид судалж, тус тусын санал, тодорхойлолтоо өгсөн байдаг.

Монголын эрдэмтэн, судлаач, дуун хөрвүүлэгчдийн зохиосон монгол, англи хэлний хэлц нэгжийн зэрэгцүүлсэн толь бичиг олон гарсны ихэнхэд нь хэлцийг утгачлан орчуулах юм уу, хэлцийг хэлцээр нь дүйлгэн оноож орчуулсан байдаг.

Хэдийгээр орчуулагч нар хоёрдогч хэлний хэлц нэгжээр илэрхийлэгдэж буй үндэстнийх нь сэтгэлгээний уламжлалт хэв шинж, өвөрмөц онцлогийг сайн мэдэж, хэлц нэгжийн утгыг яв цав дүйлгэсэн ч гэсэн орчуулгыг нь уншиж, ашиглах хүмүүст үндэстний сэтгэлгээний тогтсон хэв шинж, жишиг хэмжүүр, сэтгэлгээний онцлогийг зөвхөн дүйлгэсэн хэлц юм уу, тайлбарласан утгаар нь ойлгон төсөөлөх өрөөсгөл хандлага зарим тохиолдолд ажиглагддаг.

Хэлц нэгжийг үндэсний сэтгэлгээний онцлогийг тайлбарлах гол судлагдахуун болгохдоо тухайн үндэстний нийгэмшсэн ухамсар төлөвшихөд байгалийн юм үзэгдлийг тусган ухаарсан сэтгэхүй хийгээд сэтгэлгээний тогтсон хэв маяг(стереотип)² болон түүнийг илэрхийлэх тогтсон

1. Монгол Улсын Их Сургууль

2. Энэ тухай Ж. Баянсан, “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ”, УБ, 2002.

В.А. Маслова Лингвокультурология. Москва. 2002., 108-110;

В.Н.Телня. Русская фразеология... Москва. 1996., зэрэг номоос үзэж болно.

Т.Эрдэнэ-Очир

жишиг хэмжүүр(эталон)³-ийг илрүүлэн тайлбарлах хэрэгтэй.

Бид монгол болон англи хэлт үндэстний сэтгэлгээний тогтсон хэв шинж(stereotype), жишиг хэмжүүр(etalon)-ийг монгол, англи хэлнээ “уур, уурлах” гэсэн сэтгэл хөдлөлийн илрэл бүхий хэлц нэгжээр хэрхэн илэрч буйг зэрэгцүүлэн судлахдаа жишиг хэмжүүр болж буй адилтгагдахууныг тогтоохын тулд үгчлэн орчуулж, гарлыг нь тайлбарлахаас гадна утгаараа дүйх хэлцээр оноож орчуулахыг зорьсон билээ.

Энэ нь тухайн хэлц нэгжийг ямар утгатай хэлц нэгж болохыг тодорхойлохоос гадна **яагаад** ийм тогтвортой нэгж үүсч хэвшсэн бэ? гэдгийг аргагүйн онцлог болгож буй хэрэг юм. Профессор М. Базаррагчаагийн “... Хэлц нэгжүүдийн утга санаа ил биш, далд битүү байдаг тул сайтар задалж ухаарах хэрэгтэй болдог. Учир нь хэлц нэгж болох холбоо үг, өгүүлбэр, нийлмэл өгүүлбэр, цогцолбор нь монголчуудын (аль ч үндэстний - Т. Э-О) онцлов) ахуй амьдрал, соёл сэтгэхүйн турцлагыг хуримтлуулсан байдаг. Иймд нэг талаас уул хэлц нэгж үүсэн бүрэлдэж хэвшсэн, нөгөө талаас, тухайн хэлцийг хэрхэн дүрслэн бүтээсэн болохыг (үүсгэл утга санааг) эрх биш тайлбарлах хэрэгтэй юм.”⁴ хэмээн тэмдэглэснийг энд холбогдуулан үзүүштэй.

Аль ч хэлэнд хүний зан байдлын сөрөг үнэлэмжийг илэрхийлсэн хэлц, хэллэг, метафор зэрэг хэлний тогтвортой нэгж тооны хувьд илүү байдаг онцлогийг харгалзан “уур, уурлах” гэсэн концептыг жишээ болгон авлаа.

Монгол хэлний “Уур, уурлах” гэх концептыг тайлбар толь бичгүүдэд: **Уур** - хилэн, ихэд дургүйцэж хорсох байдал; цухалдах, хилэгнэх [Я. Цэвэл, 1966:606], **Уур** - Хилэн, ихэд дургүйцэн хорсох байдал, **Уурлах** - Хэрэг явдалд дургүйцсэнээс муу үг хэлж, цухалдах, хилэгнэх [МХДТГ 5-н боть], **Уур** - “шунал тачаал, урин (уур) хилэн, эргүү мунхаг, омог дээрэнгүй, атаа найдангүй зэрэг нь ишвэицсийн тэвч, хор, бэццэ” [Ц. Чоймаа нар., Буддын шашин соёлын тайлбар толь-2000:129], Ч. Дандаагийн “Эрдэнэт толь”-д “Уур хэмээгч бусдад уурлах, хилэгнэх нь буюу. Эцэг эх ба багш ихэс ба ах зах ба насжсан отгоост хэдэрлэж хариуцах ба ах дүү ба уриг сидан ба энгийн хүн, эм хөвгүүд ба доор ардад зүй бусаар уурлаж ашилахыг уур хэмээмүй. Үүнээс хорсох занх сэтгэл төрөгдөнө.” гэх мэтээр утгыг тус бүрт нь тайлбарласан байна.

Харин хэлц нэгжээр “**шар нь хөөрөх, шар нь буцлах, шар нь хөдлөх, шар нь гозойх, шар нь бадрах, шар хусах, шар хөдөлгөх, шар хөөрөх ~ шар нь хөөрөх, шар гаргах, шарыг нь малтах, хилэн төрөх, хилэн бадрах, хилэн төрөх, унтуу хөдлөх, хор буцлах, хор хөдлөх, хорыг нь маажих, хорыг нь малтах, хор шар нь буцлах, хор шарыг нь малтах, хор шар хөдлөх, тэвүү хүрэх, омог/уур нь шатах, омог төрөх, цөс цалгих, уушги зүрх амаар гарах шахах, уушги зүрх сагсайх, зүрхний хий нь хөдлөх, газар тэнгэр нийлүүлэх, дээлэндээ багтахгүй болох, залаа нь гозойх (зан нь хувирч залаа нь гозойх), нүднээс нь оч бутрах, ямаан омог нь хөдлөх, хомсөг атираа**”⁵ гэх мэт байна. Үүнийг судалгааныхаа зорилгод нийцүүлэн хэлц тус бүрээр нь задлан тайлбарлавал:

• шар нь хөөрөх (уур нь хүрэх), шар нь буцлах (уур омог ихэд хөдлөх), шар нь хөдлөх (уур омог нь хүрэх, шар гозойх), шар нь гозойх (хор шар хөдлөх, омгорхох), шар нь бадрах (уур нь хүрэх), шар хусах (уур омог хүрэх), шар хөдөлгөх (уурыг нь хүргэх), шар хөөрөх ~ шар нь хөөрөх (а. Шар хусах; б. Уур омог нь бадрах), шар гаргах (уур, омог гаргах), шарыг нь малтах

3 Мөн тэнд..

4. Базаррагчаа, М. “Монгол хэл” (Наймдугаар анги), 1999, 9-р нүүр..

5. МУШУА, “Монгол Хэлний Дэлгэрэнгүй Тайлбар Толь” 5-н боть, УБ, 2007 он..

Я. Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ, 1966..

Г. Аким, “Монгол хэлний өвөрмөц хэлцийн тайлбар толь”, УБ., 1982 он..

Монсудар хэвлэлийн газар, “Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь”, УБ., 2011 он..

Т.Эрдэнэ-Очир

(муу үг хэлж дургүйг нь хүргэх, уурыг нь хүргэх) гэх мэт дээр дурдсан концептийг илэрхийлэх хувилбар хэлцүүдэд “**шар**” гэсэн жишиг хэмжүүр (Etalon) буй нь харагдаж байна.

Энэ жишиг хэмжүүрийн утгыг уг концепттой холбогдуулан тайлбар толь бичгүүдээс нэхэн үзвэл, *шар – уур, омог. (Шар гаргах – омогтой зан гаргах)* [Я. Цэвэл, 1966:838], *Шартай-ууртай, омогтой, дээрэлхүү* [Я. Цэвэл, 1966:840], *Шар - Уур, омог.* [МХДТТ, 5-н боть] гэх мэтээр тайлбарласан байна.

Харин “**шар**” гэх үг яагаад “**уур, уурлах**” гэх концептын жишиг хэмжүүр (etalon) болдог талаар дурдсан зүйлгүй байна.

Бидний үзэхээр, монгол хэлний “шар” гэх үг “уур, уурлах” гэх концепт илэрхийлэх хэлц нэгжийн *жишиг хэмжүүр* болж буйн гарлыг “**цөс**”-тэй холбон тайлбарлаж болохоор байна. Монгол хэлнээ “*цос ихт баатар эр (омог хүчтэй)*” [МАЗ], *цос нь цалгих, цос нь хоорох (уур нь хүрэх, хитэн нь хөдлөх)* гэх мэт илэрхийллүүд байх ба элэгнээс боловсруулан гаргах **шар ногоон өнгөгэй, гашуун, хурц** үнэр амт [Я. Цэвэл, 1966: 796] бүхний цөс⁶ хэмээх шүүрлийн эрхтний өнгө, шинж чанарыг танин мэдсэнтэй холбоотойгоор “шар” гэх үг төлөөлөл (метоним) болж үүссэн байж болох.

Нөгөө талаас, буддын шашны болон уламжлалт анагаах ухааны сударт “**шар**” бол “*хий, шар(цөс), бадган(шүлс)*” хэмээх *гурван махбодийн нэг*⁷ бөгөөд “**шар**” нь “*халуун, хурц, тослог, хонгон, үнэрлэг, суулгах, нойтон зэрэг бэлгэ чанартай. Тэрчлэн бие, сэтгэлийн үйл ажиллагаа энэ гурвын зохирлоос шалтгаалдаг*”⁸ гэж тэмдэглэснээс үзвэл Монголд дэлгэрсэн Буддын шашин хийгээд түүнийг даган дорнын уламжлалт анагаах ухааны сургаал номлол, судар бичиг дэлгэрч, өрнөсөн үйл явдалтай холбогдуулан авч үзэх үндэслэл байж болохыг харгалзах учиртай байна.

Харин англи хэлэнд “**vent your spleen**” [цөсөнд нь хий орох] гэсэн хэлц байдаг. Үүний гарлыг мөшгин үзвэл хүний хамгийн муу муухай зан чанарууд цөснөөс үүсэн буй болдог гэсэн уламжлалт ойлголтоос үүдэлтэй. Энэ талаар дэлгэрүүлэн дурдвал, эртний Грекийн гүн ухаантан Гипократ (Hippocratic) –ийн үндэслэснээр сэтгэл хөдлөлийн үндсэн дөрвөн төлөв (temperament) байх бөгөөд эдгээр нь хар цөс (black bile), **шар цөс** (yellow bile), цэр, зунгаг (phlegm), цус (blood) гэсэн дөрвөн зүйлийн шингэний зохицлоос шалтгаалахаас гадна хүний идэж уух хоол хүнс, үйл хөдлөлөөс хамааран энэхүү дөрвөн зүйл шингэний аль нэг нь хэвийн хэмжээнээс ихсэх юм уу багасах гэх мэтээр тогтворгүй болох нь аливаа өвчин эмгэгийн шалтгаан болдог гэдэг үзлээс эхтэй. Хүний биен дэх энэхүү дөрвөн зүйл шингэний тухай үзэл онол нь (the humoral theory) Грек, Ромын хийгээд хожим Баруун Европын болон Лалын шашинт сэтгэл судлаач, гүн ухаантнуудын итгэл, үнэмшлийг олж, Европт орчин үеийн анагаах ухааны үндэс суурь тавигдаж эхэлсэн XIX зуун хүртэл, анагаах ухааны гол үзэл онол болж байв.

Мөн энэхүү дөрвөн зүйл шингэн нь дөрвөн махбодийн онолтой холбоотой бөгөөд хар цөс нь шороон, **шар цөс нь гал**, цэр зунгаг (phlegm) нь усан махбодтой байх ба цус нь хий, шороо, гал, ус гэсэн дөрвөн махбодийн аль алиныг агуулдаг гэж үздэг аж. Түүнчлэн дөрвөн махбодийн онол үүссэн цаг үетэй ойролцоо цаг үед эртний Энэтхэгийн Аюурвед хэмээх анагаах ухааны сургаал буй болсон бөгөөд сэтгэлийн төлөв байдлын гурван хэлбэрийг таван махбодтой холбон

6. Элэгний эсээс боловсорч гардаг ус, цөсний хүчил, пигмент, холестерин, даавар, фермент агуулсан шүүрэл [Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (Таван боть) УБ, 2007 он..]

7. Б. Жигмэд, Монгол анагаах ухааны түүх болон эртний сурвалж бичгийн шинжилгээ, УБ, 2009 он., 101-104-р тал.,

8. Ш. Чоймаа, Л. Тэрбиш, Д. Бүрнээ, Л. Чулуунбаатар нар. Буддын шашин, соёлын тайлбар толь, (Буддын судлал, Цуврал II), УБ, 2000 он., 391-392-р тал.

Т.Эрдэнэ-Очир

тайлбарласан байдаг. Дээр дурдсан хүний дөрвөн зүйл шингэн хийгээд дөрвөн махбодийн онолтой хүний бие эрхтэн, зан төлөв хэрхэн холбогддог болохыг хүснэгтлэн үзүүлбэл:

Шингэн	Улирал	Махбод	Эрхтэн	Шинж чанар	Эртний нэр	Зан төлвийн онцлог
Цус	Хавар	Хий	элэг	Халуун чийглэг	sanguine	Өөртөө итгэлтэй, дурламтгай
Шар цөс	Зун	гал	цөс	Хуурай, халуун	choleric	Амархан уурладаг, муухай ааштай
Хар цөс	Намар	шороо	Цөсний уут	Хүйтэн, хуурай	melancholic	Гутранги, сонор соргог, мэдрэмтгий
Цэр зунгаг	Өвөл	Ус	Тархи, уушиг	Хүйтэн, чийглэг	phlegmatic	Тайван, сэтгэлийн хөдлөл багатай

Үүнчлэн уг “шар” гэх жишиг хэмжүүрийг, уурын мунхагаас шалтгаалан үүсэх атаа хор, хор хар, хорт сэтгэлийн “хор”⁹-той адилтган хоршуулж үүсгэсэн “хор шар” гэх жишиг хэмжүүрээс “хор буцлах (атаархах сэтгэл ихэд хөдлөх, бусдаас дутахгүй юмсан гэж тэчъяадах), хор хөдлөх (ямар нэг зүйлийг санасандаа хүртэл хийж чадаагүйдээ хорсон тэчъяадах), хорыг нь маажих (хорыг нь малгах, шарыг нь гозойлгох, хүнийг үгээр басамжлан доромжилж атааг нь хөдөлгөх), хор шар нь буцлах (хор буцлах), хор шарыг нь малгах (хор маажих), хор шар хөдлөх (хор шар буцлах), хорыг нь малгах (гэчъяадам үгээр басамжлан эгдүүг нь хүргэх, муу үг хэлж унтууцуулах), атаа хор *хоршоо* 12 (бусдын давуутай байдалд мөчөөрхөн тэчъяадах сэтгэл), хор хар *хоршоо* 12 (атаа хорсол), хор шар *хоршоо* 12 (атаа хорсол, хор хөдөлснөөс болж гаргах муу зан авир), хор ихтэй хүн (атаархах сэтгэл ихтэй хүн) гэх мэт хэлний тогтвортой нэгжүүд үүсчээ гэж үзэж болох юм.

Харин “уушиг зүрх амаар гарах шахах (а. айж почих; б. ихэд аахилан амьсгаадах; в. хэт цухалдах) [МХДТТ 5-н боть], уушиг зүрх сагайх (ихэд уурлах, бачимдах), зүрхний хий нь хөдлөх (а. түргэн, цочмог уурлах, б. онгирах, сагсуурах) гэх мэт хэлц нэгжүүдийг хүний сэтгэл хөдлөлийн төлвүүд (баярлах, гунигдах, уурлах, айх, ичих, гайхах...) физиологийн үйл явцтай (биеийн мах бодийн тогтолцоотой) шууд холбоотойгоор илэрдэг мэдрэмжийг хүмүүс төрөлх гэнэн төсөөллөөр (найвная картина/ naive understanding) адилтган нэрлэдэг ерөнхий зарчимтай холбогдуулан тайлбарлах боломжтой юм.

Ю. Д. Апресян. Хүмүүс гэнэн төсөөллөөрөө (найвная картина) хүний сэтгэл хөдлөл болон бие эрхтний үйл явц хоорондын хамаарлыг хэлэндээ хэрхэн илэрхийлдэг болохыг хэлний баримтад тулгуурлан гайлбарласан байдаг¹⁰. Түүний тэмдэглэснээр, “Хүн ертөнцийг танин мэдэхдээ шинжлэх ухааны юмуу төрөлх гэнэн төсөөллийн (найвная картина) гэсэн хоёр арга замаар мэдээллийг хүлээн авч оюун дүгнэлт хийдэг. Түүнчлэн *хүн гадаад ертөнцийн туршилагаас загварлан дотоод сэтгэлгээний зураглалыг буй болгохдоо*¹¹ өвөрмөц, гаж үзэгдэл, мэдрэмжийг өөрг хамгийн ойр эгэл зүйлийн гөстэй шинжээр адилтгаж, гэнэн төсөөллийн аргаар шинэ нэрлэлт үүсгэдэг. Жишээ нь: Хүний айхдаа мэдэрсэн мэдрэмж нь хүйтэнд бие нь даарснаас болж чичирдэг (дрожать от холода) мэдрэмжтэй адил санагддаг учир айснаас болж чичрэх (дрожать от страха), айснаас болж голд хүйт орох (страх леденит душу – айдас сэтгэлийг царцаах) гэх мэтээр нэрлэлт үүсгэдэг. Үүний нэгэн адил, уур хүрэхэд хүний дотор нь гал асаж байгаа юм шиг, халуун хий дүүрсэн мэт мэдрэмж буй болж, дотор байгаа гал мэт

9. Агаархан гэсч ядан хорсох сэтгэл [Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (Таван боть) УБ, 2007 он.]

10. Ю. Д. Апресян. “Образ человека по данным языка: попытка системного описания”. Вопросы языкознания. 1995 г. Москва..

11. Энэ санааг Н. Д. Арутюнова “Поскольку внутренний мир человека моделируется по образу внешнего, материального мира, основным источником психологической лексики является лексика “физическая”, используемая во вторичных, метафорических смыслах” – “Хэдийгээр хүний дотоод ертөнц нь гадаад буюу материаллаг ертөнцийн дүрээр загварлан бүтдэг боловч сэтгэл хөдлөлийн үндсэн эх сурвалж нь “биеийн” үгийн сан байдаг бөгөөд энэ нь зүйрлэлийн утгаар хэрэглэгддэг.” гэж тэмдэглэсэн байдаг. [Н. Д. Арутюнова. Предложение и его смысл. М., 1976.]

Г.Эрдэнэ-Очир

зүйлийг гадагшлуулахыг хүсэх, уур хүргэх шалтгаан болсон зүйлийг устгах, зангах, өс хонзон өвөрлөх, хариу авах гэх мэт хүсэл төрдөгөөс үүдэлтэйгээр “уур” гэх концептын утга агуулгыг илэрхийлэх нэрлэлтүүд үүсдэг.

Мөн сэтгэлийн хөдлөл, биеийн хөдөлгөөнөөр илрэх илрэлийг “хяналттай” буюу зориудаар илрэх (контролируемые физиологические реакции) “айхаараа - нуугддаг, зугтдаг, уурлахаараа – дайрч давшилдаг”, харин “хяналтгүй” буюу аяндаа илрэх (неконтролируемые физиологические реакции) нь гайхахаараа - *нүдээ бүлтийлгэдэг, уурлахаараа - хомсгөө зангиддаг, гариа зангиддаг, шүдээ зуудаг, ичихээрээ - нүүр нь улайдаг* гэж ангилж болно.¹² гэж үзжээ. Гэнэн төсөөлөл (найвная картина) хэмээсний учир нь сэтгэлийн хөдөлгөөний байдал нь биеийн хөдөлгөөн, төлөв байдлаар илрэх үед дотоод цочролын хариг урвалын үр дүнд үүсч буй үйл явцыг шинжлэх ухааны нарийн задлал хийж ойлголтгүй зөвхөн тухайн агшинд өөрт мэдрэгдэж буй мэдрэмжид тулгуурлан оюун дүгнэлт хийсэнтэй холбоотой гэж тайлбарласан байна.

Дээр дурдсан “зүрхний хий нь хөдлөх, уушги зүрх амаар гарах шахах, уушги зүрх сагсайх” зэрэг хэлц нэгжүүдэд “зүрх болон уушги” гэх үг тулгуур үг болохдоо “зүрх догдлох (сэтгэл ихэд хөдлөх), зүрх дэлбэрэх (үнхэлцэг хагарах), зүрх түгших (сэтгэл санаа тавгүйтэх), зүрх алдах (айж төвөгшөөх), зүрх үхэх (шантрах, бэрхшээх, халширах), зүрх нь чичрэх (айж эмээх)” гэх мэт сэтгэл хөдлөлийн утга илэрхийлэх нэгэн зүйл “утгын орон” болж байна.

Гэвч зөвхөн “зүрх” гэсэн үгийг жишиг хэмжүүр (etalon) гээд “зүрх” гэсэн үг орсон дээрх бүх хэлцийг нэг концептын утга илтгэж байна хэмээн үзвэл өрөөсгөл болно. Учир нь эдгээр хэлцэд “зүрх” гэдэг үг тулгуур үг болж байгаа ч энэ үгтэй холбогдож өвөрмөц хэллэг үүсгэлцэж байгаа үйл үгсийн утга, үүргийг ажиглаж байж, концептын нарийн утгын ангиллыг хийж чадна.

Бидний сонгосон “уур, уурлах” гэх концептыг илэрхийлж буй “зүрхний хий нь хөдлөх, уушги зүрх амаар гарах шахах, уушги зүрх сагсайх” гэсэн хэлцүүдийн “хөдлөх, гарах, сагсайх” зэрэг үйл үгсийг ажиглавал, “тогтворгүй, идэвхтэй хөдөлж байгаа” гэсэн ерөнхий санааг илтгэж байгаа нь тухайн сэтгэл хөдлөл (уурлах) үүсэхэд хүний төв мэдрэлийн систем цочирч, цусны эргэлт хурдсан, улмаар зүрхний хэм хэвийнхээсээ түргэсч, цусны гүйдлийн физиологи шинж, түүнтэй уялдаж үүсэх мэдрэлийн эд, эс, судлын харилцан нөлөөллөөс шалтгаалалцсан нэгэн зүйл эрчим хүч бие цогцост үүснэ хэмээн төсөөлөн ойлгож болмоор байна. Энэ эрчмийг хүн мэдрэхдээ нөхцөлмөл хам орчноос шалтгаалж гэнэн төсөөллийн аргаар (найвная картина) янз бүр нэрлэдэг байна.

Мөн хилэн төрөх (уурлах, хилэгнэх), хилэн бадрах (ихэд уурлан бухимдах), унтуу хөдлөх (уур хүрэх), зэвүү хүрэх (юмыг жигшин үзэх, зэвүүцэх), омог/ уур нь шатах (ааг, шар нь хөдлөн хөөрөх), омог төрөх (ааг, шар нь хөдлөх) гэх мэт хэлцүүдийг хэлбэр, бүтцийнх нь талаас ажиглавал “уур” гэсэн үгтэй ойролцоо утгаг “хилэн, уцаар, унтуу, омог, зэвүү” гэсэн нэр үгс нь “хөөрөх, хөдлөх, төрөх, гозойх, хүрэх” гэх мэт үйл үгстэй нийлж хэлц бүтээснийг “Уурлах” гэсэн сэтгэл хөдлөлийн “үе шат”-ыг төсөөлөн тодорхойлбол, “төрөх, хүрэх” нь уурлахын эхлэл, “хөдлөх” нь өрнөл буюу удаах үе, харин “хөөрөх, гозойх” нь эцсийн буюу оргил үе нь болох мэт ажээ. Ийнхүү адилтгах нь дээр дурдсан, гэнэн төсөөлөлтэй холбоотой болов уу гэж санагдана.

Гэтэл “ямаан омог нь хөдлөх” гэх хэлц нь “ялихгүй юманд гэнэт дүрсхийн омогшивч, мөдхөн, гэрхэн зуураа намждаг омог” (ааш араншин)-ийг тодорхойлон адилтгасан нэрлэлт

12. Ю. Д. Апресян, “Образ человека по данным языка: попытка системного описания”, Вопросы языкознания, 1995 г, Москва.

Т.Эрдэнэ-Очир

юм. Ийн адилтгасны учрыг нягталбал. монгол хүний үзэлт (сэтгэлгээ)-ээр ямаа бол хонийг бодоход янгууч, тэсвэр тэвчээр муутай амьтан” гэж ойлгож ухаарсан төдийгүй, бас түүний нь “таашаахгүй” байдаг үнэлэмжтэй цаагуураа холбоотой байна уу гэлтэй. Ийм учраас “ямаан омог нь хөдлөх” гэсэн хэлц “дэмий”, “зохисгүй” гэсэн үнэлэмжийн утгатай.[Ж. Баянсан, 2002]. Үүнээс үзвэл, энэ хэлцийн үүсэл нь уг хэлцдээ жишиг хэмжүүр болж буй “ямаа”-ны араншин танин мэдсэн туршлага хийгээд монголчуудын эртнээс нааш мал маллаж ирсэн уламжлалт аж төрөх ёсны хэв маягтай шууд холбоотой гэж үзэж болно.

Бид “уур, уурлах” гэсэн концепт илэрхийлэх англи хэлний 30 гаруй хэлц нэгжийг жишээ болгон сонгохдоо холбогдох тайлбар толь бичгүүдээс гарал үүсэл буюу адилтгагдахууныг эрж, тус бүрд нь тайлбарыг хадаад, уг жишээ баримтад тулгуурлан англи хэлт үндэстний сэтгэлгээний хэв шинжит хэмжүүрийг агуулгаар нь ангилахыг оролдсон болно.

“Улаан, халуун, гал шиг” гэсэн хэмжүүрт багтах:

1. **hot under the collar** [Захан доорх халуун] бухимдсан, уурласан (хэт цухалдан дотор нь давчдаж халуусснаас зангиагаа суллаж, цамцныхаа хоолойн товчийг тайлдагтай холбоотойгоор үүссэн [Oxford Dictionary of Idioms, 2004]) - **дээлэндээ багтаж ядах.**

2. **breathe fire** [галаар амьсгалах] – дэлбэртлээ уурлах, (шидэт үлгэр, зөгнөлт зохиол, кинонд гардаг “уурлахаараа галаар үлээдэг луу хэмээх амьтан”-тай холбоотойгоор үүссэн. [Cambridge International Dictionary of Idioms, 2002]) - **Ааг омог нь дүрэлзэх,**

3. **a face like thunder** [Аянга/цахилгаан шиг нүүр]¹³ – ихэд уурлах - **хилэн нь бадрах, дэлбэртлээ уурлах,**

4. **makes one’s blood boil** [хэн нэгний цусыг буцалгах]¹⁴ маш ихээр уурлах, - **хорыг нь мялтах;**

5. **do a slow burn** [удаанаар гал асаах]¹⁵ – тэвчээр нь барагдаж уурлах, - **уураа барьж ядах.**

6. **to see red** [Улааныг харах] (Бухтай тулалдах тэмцээний үед бухыг уурлуулахын тулд улаан даавуу, дарцаг ашигладаг зан үйлтэй холбоотойгоор үүссэн¹⁶. Уурласан буханд улаан дарцаг үзүүлэх) – **хилэнг нь хөдөлгөх,**

7. **scarlet with rage** [минчийж улайртлаа уурлах] - **улаан галзуу уурлах, галзууртлаа уурлах,**

Амьтантай холбоотой жишиг хэмжүүр:

1. **Ruffle (sb’s) feathers** [өд сөд нь өрвийх/ өд сөдийг нь өрвийлгөх], (зарим төрлийн шувууд уурлахаараа далавчаа дэлгэн өд сөдөө өрвийлгөн сэгсийлгэдэг онцлогтой холбоотойгоор үүссэн¹⁷) - **сэрвээний үс нь босох.**

2. **Be like a bear with a sore head** [Толгойндoo шархдсан баавгай шиг болох] – А. уурлаж бухимдсан, Б. үргэлж зовлон тоочиж байдаг гэсэн 2 утгатай¹⁸. монгол хэлнээ уурласан гэх утга

13. Cambridge International Dictionary of Idioms, The press syndicate of the university of Cambridge, United Kingdom, 2002..

14. Oxford Dictionary of Idioms, Edited by Judith Siefring, Oxford University Press, UK, 2004..

15. Мөн тэнд..

16. Мөн тэнд..

17. <http://www.etymonline.com/index.php?term=idiom>

18. Cambridge International Dictionary of Idioms, The press syndicate of the university of Cambridge, United Kingdom, 2002..

нь улайрсан чоно шиг, өлссөн барс шиг, улангассан бух шиг гэх мэт адилтгалаар дүйж байна.

3. **fla in one's ear** [чихэнд орсон нохой бөөс]- бухимдуулах, дургүйг нь хүргэх¹⁹ – нүдний цагаанаар харах, /нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах болох/ дотор арзагнуулах,

4. **Rub someone up the wrong way** [Хэн нэгнийг буруу замаар үрэх, илэх] – уурлуулах, (Муур мэт гэрийн тэжээмэл амьтны нурууг нь сөргүүлж илэхэд дургүйцдэг үйлээс үүдэлтэй²⁰.) - тахилыг нь буруу өрөх,

Бие эрхгнээр жишиг хэмжүүр:

1. **foaming at the mouth / froth at the mouth** [амандаа хөөстэй] - галзууртлаа уурлах (хүн амьтанд тусдаг галзуу өвчний нян хүнд халдахдаа ихэвчлэн нохойноос халдварладаг бөгөөд энэ өвчнөөр өвчилсөн хүний хоолой, багалзуур нь боогдож амьсгалахад хэцүү болж амаар нь хөөс дүүрдэг. Энэ дүрслэлээс үүдэн ихээр бачимдаж уурласан хүнийг Виллям Шекспир 1601 онд бичсэн "Julius Caesar" зохиолдоо анх тэмдэглэгджээ²¹.)

2. **be fed up to the back teeth** [агт араанаасаа уйдаж, залхах] – ямар нэгэн таагүй нөхцөл байдал шийдвэрлэгдэхгүй удаан үргэлжилснээс болж бухимдан уурлах. (Дэлхийн нэгдүгээр дайны үед Америкийн армийн цэргүүдийг хэзээ халагдах нь тодорхойгүй ург хугацааны цэргийн алба хаалгаж байсантай холбоотойгоор үүссэн²².) – гэвчээр барах, тэсгэл алдуулах,

3. **(almost) burst a blood vessel** [судас нь дэлбэрэх/ задрах] – галзуурах шахах, маш ихээр уурлах²³ - шар нь хөөрөх, омог нь шагах,

4. **vent your spleen** [цөсөнд нь хий орох] – (Хүний хамгийн муу муухай зан чанарууд цөснөөс үүсэн буй болдог гэсэн уламжлалт ойлголтоос үүдэлтэй²⁴.) Энэ талаар дээр тайлбарласан болно. – Зүрхний хийтэй,

5. **Spit blood** [цусаар нулимах, цусаар тургих] – ихэд уурлан хашгичих, үсэрч цовхрон уурлах²⁵, - уур нь хүрч, уушиг нь сагсайх,

Байгаль, цаг ууртай холбоотой:

1. **a storm brewing** [аадар борооны үүл хуримтлуулах] – уураа барьж ядах ,

2. **a face like thunder** [Аянга/цахилгаан шиг нүүр] – Хор нь буцлах,

3. **tempest in a teapot** (American English), **a storm in a teacup** (British English) [цайны аяган доторх/ данхан доторх шуурга] – ямар нэгэн онцын ач холбогдолгүй зүйлийн талаар санаа зовж уурлах, (МЭӨ 52 онд сэтгэгч Цицироны бичсэн нэгэн зохиолоос үүдэлтэй²⁶.) - ямаан омог нь хөдлөх.

19. Cambridge International Dictionary of Idioms. The press syndicate of the university of Cambridge, United Kingdom, 2002.,

20. <http://english.stackexchange.com/questions/13874/origin-of-rub-someone-the-wrong-way>

21. <http://www.knowyourphrase.com/phrase-meanings/Foaming-At-The-Mouth.html>

22. <http://wordoriginsorg.yuku.com/topic/8016#.UJ3sMeTqn-U>

23. Cambridge International Dictionary of Idioms. The press syndicate of the university of Cambridge, United Kingdom, 2002.,

24. <http://funwithenglishblog.com/2011/11/vent-your-spleen/>. http://wiki.answers.com/O/What_is_the_origin_of_the_idiom_'vent_your_spleen'

25. Oxford Dictionary of Idioms, Edited by Judith Siefring, Oxford University Press, UK, 2004.,

26. http://en.wikipedia.org/wiki/Tempest_in_a_teapot

Амьдралын хэв маягтай холбоотой:

1. **to be on the warpath** [дайны зам дээр байх] тулалдахад бэлэн болсон, их уурласан. (Уугуул Америкчуудын “дайнд явж байгаа” гэсэн хэллэгээс үүдэлтэй²⁷.) – **яахаас ч буцахгүй болтлоо уурлах,**

2. **hit the roof/ ceiling** [дээвэр / тааз нүдэх] - хашгичан уурлах (Үсэрч цовхрон уурлахдаа толгойгоороо тааз мөргөхөөс үүсэлтэй²⁸.) - **цамнаж гарах, нэг дуу тэнгэрт, нэг дуу газарт,**

3. **count to ten** [арав хүртэл тоолох] – А. тэвчээр нь барагдаж уурлах. Б. тайвшрах (Хойд Америкт үүссэн боксын тэмцээний үед нэг өрсөлдөгч нөгөө өрсөлдөгчөө хүнд цохилтоор унагахад, цохилтод орсон өрсөлдөгч шүүгчийг арав хүртэл тоолж дуусахаас өмнө босч чадахгүй бол ялагддаг байсан дүрэмтэй холбоотойгоор үүсчээ²⁹.) -

4. **fly off the handle** [барьц алдах] – биеэ барьж дийлэхгүй уурлах³⁰, - **тэгсгэл алдах, хилэн нь бадрах,**

5. **Jump down sb's throat** [хэн нэгний хоолой руу үсэрч буух] – дургүйцлээ илэрхийлж уурлах, - **барьж идэх шахах,**

6. **go bananas** [гадиланд явах] - (Канад, Хойд Америкт гадил жимсийг исгэж шар айраг, архи нэрдэг уламжлалтай бөгөөд энэ төрлийн архийг ууж согтсон хүн шиг гэсэн адилтгалаас үүссэн байна³¹.) - **биеэ барьж дийлэхгүй уурлах**

Бидний жишээ болгон авсан англи хэлний “уур, уурлах” гэх концептийг илэрхийлэх хэлцүүд нь Лаккоф, Ковечес³² нарын судалсанчлан *саван дотор буй халуун шингэн шинг* (hot fluid in a container), *гал шинг* (fire), *аймшигт амьтан шинг* (dangerous animal), *өрсөлдөгч, дайсан шинг* (opponent), *дарамт шахаат шинг* (burden) гэх мэт адилтгалын хүрээнд илэрдэг” гэж үзсэнтэй нийцэж байна.

Үүнээс үзэхэд англи, монгол хэлт үндэстний уламжлалт аж төрөх ёс, шашин соёл, ергөнцийг үзэх үзэл, тэдгээрийг үнэлэхдээ ямар зүйлийг тогтсон хэмжүүр болгож ангилдагийн өвөрмөц онцлог нь хэлнийхээ хэлц нэгжүүдэд тодорхой туссан байдгийн нэгээхэн баримтыг бидний авч үзсэн концептын жишээнээс харж болохоор байна.

Түүнчлэн энэхүү хоёр өөр соёл хэлтний нэг утга санааг (нэг концепт) өөр өөр жишиг хэмжүүр бүхий хэлц нэгжээр илэрхийлдэг нь тухайн соёл – хэлт үндэстэн угсаатны аж төрж ирсэн газар нутгийн тогтоц байдал, тэнд ургаж, төлжсөн ургамал амьтан, тэнд орчиж байдаг байгалийн үзэгдэл, уг үндэстэн угсаатны уламжлалт аж төрөх ёс, арга ухаан, амьдралын хэв маяг, ёс заншил, зан үйл, шашин шүтлэг, хорио цээр, бэлгэдэл ерөөл, бүтээн цогцлоож, уламжлан өвлүүлж ирсэн эд өлгийн болон оюун билгийн соёлын өвөрмөц зүйл, онцлог болгонтой салшгүй холбоотой байдаг учраас хоёр хэлний зэрэгцүүлсэн толь бичиг зохиохдоо аль аль хэлнийх нь хэлцийн гарал, үүсэн хэвших болсон онцлогийг нарийн тайлбарлахаас гадна үгчилсэн орчуулгыг хадаж өгөх нь адилтгагдахууныг танихад ач холбогдолтой хэмээн үзэж байна.

27. <http://www.phrases.org.uk/meanings/on-the-warpath.html>

28. Cambridge International Dictionary of Idioms. The press syndicate of the university of Cambridge, United Kingdom, 2002.

29. Oxford Dictionary of Idioms, Edited by Judith Siefring, Oxford University Press, UK, 2004.

30. Мөн тэнд.

31. http://wiki.answers.com/Q/What_is_the_origin_of_the_expression_GOING_BANANAS

32. Lakoff G, Kovecses Z: The cognitive model of anger inherent in American English; in Holland D, Quinn N (eds): Cultural Models in Language and Thought. New York, Cambridge University Press, 1987.

Т.Эрдэнэ-Очир
АШИГЛАСАН ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

1. Аким. Г. Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь, УБ, 1982.
2. Апресян. Ю. Д. "Образ человека по данным языка: попытка системного описания". Вопросы языкознания, 1995 г.,
3. Базаррагчаа. М. Монгол хэл, УБ, 1999.,
4. Баянсан. Ж. "Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ", УБ, 2002.,
5. Бат-Ирээдүй. Ж. Монгол хэлний хэлц үг, хэллэгийн утга, хэрэглээ, УБ, 2007.
6. Бат-Ирээдүй. Ж. Г. Ариунжаргал, Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат хэлц үгийн сан. УБ, 2007.,
7. Бат-Ирээдүй. Ж. Номинзул. Б.. Монгол – Англи хэлц үг, хэвшмэл хэллэгийн дүймэн. УБ, 2007.,
8. Баттогтох. Д. "Зуун хэлц, дасгал, сорилго", УБ, 2006.,
9. Дашдаваа. Г. Сумьяа. Ц, Англи хэлний хэвшмэл хэллэгийн товч толь, УБ, 1999.,
10. Жигмэд. Б., Монгол анагаах ухааны түүх болон эртний сурвалж бичгийн шинжилгээ, УБ, 2009.,
11. Маслова. В.А.. Лингвокультурология. Москва. 2002.,
12. МУШУА. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (Таван боть) УБ, 2007 он.
13. Өвгөнхүү. Б., Англи хэлний өвөрмөц хэллэгийн тайлбар бэсрэг толь, УБ, 2006.,
14. Өнөрбаян. Ц., Монгол хэл. (наймдугаар анги), УБ, 2007.,
15. Цэвэл. Я., Монгол хэлний товч тайлбар толь, УБ, 1966.,
16. Ш. Чоймаа, Л. Тэрбиш, Д. Бүрнээ, Л. Чулуунбаатар нар. Буддын шашин, соёлын тайлбар толь, (Буддын судлал, Цуврал II), УБ, 2000 он.,
17. Энхцацар. Т., Хэлц үйл үгийн толь бичиг, УБ, 2001.,
18. Cambridge International Dictionary of Idioms. The press syndicate of the university of Cambridge. United Kingdom. 2002.,
19. Oxford Dictionary of Idioms. Edited by Judith Siefring. Oxford University Press, UK, 2004.,
20. Lakoff G, Kovecses Z: The cognitive model of anger inherent in American English; in Holland D, Quinn N (eds): Cultural Models in Language and Thought. New York, Cambridge University Press, 1987.
21. Merriam – Webster’s Advanced Learner’s English Dictionary. Edited by Stephen J. Perrault. USA. 2008.
22. **Цахим хаягууд:**
<http://english.stackexchange.com/questions/13874/origin>
<http://www.knowyourphrase.com/phrase/>
<http://wordoriginsorg.yuku.com/topic/8016#.UJ3sMeTqn-U> <http://funwithenglishblog.com/>
<http://wiki.answers.com/>
<http://en.wikipedia.org/wiki/>

Т.Эрдэнэ-Очир

<http://www.phrases.org.uk/meanings/>

<http://www.phrases.org.uk>

<http://www.etymonline.com/index.php?term=idiom>

[http://wiki.answers.com/O/What is the origin of the expressions](http://wiki.answers.com/O/What_is_the_origin_of_the_expressions)

ABSTRACT

This paper related to methodology of English-Mongolian dictionary of idioms. According to the idiomatic expressions can be basic subject to study mentality of nations, author highlighted to explain the origins of phrases, idioms and examples of their use. Moreover, one of the important methods is to add a parallel translation and literally translation, its needs to identify etalon of idioms and mentality of speaking both language peoples. Author taking as examples of idioms which represents the "Anger" concept in Mongolian and English.